

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/111/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 422

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Олон нийтийн цагдааг томилон ажиллуулж үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас цалинд 11,583.6 мянган төгрөг, хувцас хэрэглэлд 1,500.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас цол ахиулан амжилт гаргасан бөхөд 1,500.0 мянган төгрөгийн мялаалга, хичээл үйлдвэрлэлийн зардлаас малчдын сургалт, сурталчилгаанд 2,000.0 төгрөгийг тус тус зарцуулж төсвийг зориулалт бусаар зарцуулсан, байгууллагын хэрэгцээнд 2 төрлийн интернэт сүлжээг зэрэгцүүлэн ашиглаж 3,509.0 мянган төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан, ээлжийн амралттай байх хугацаанд 2 ажилтанд 791.3 мянган төгрөгийн цалинг тус тус илүү тооцон олгосон зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 631,624.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 422.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 612,958.5 мянган төгрөгийг зарцуулж, 19,088.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 24,535.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 21,426.5

мянган төгрөгийг зарцуулж, 3,109.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 246,478.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 225,594.3 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, ээлжийн амралттай байх хугацаанд 2 ажилтанд 791.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцон олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан 20,092.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилт 87 хувьтай дүгнэгдсэн байна Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	105,319,685.52	100,825,654.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,933,072.00	1,083,072.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,933,072.00	1,083,072.00
3121	Төгрөг	3,933,072.00	1,083,072.00
31211	Төрийн сангийн харилцах	3,933,072.00	1,083,072.00
33	АВЛАГА	5,013,062.52	4,991,133.00
335	Бусад авлага	5,013,062.52	4,991,133.00
3351	Байгууллагаас авах авлага	3,070,415.52	3,229,186.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,942,647.00	1,761,947.00
34	УРЬДЧИЛГАА	1,995,767.00	1,745,767.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,382,462.00	1,382,462.00
3471	Урьдчилгаа тооцоо	613,305.00	363,305.00
34713	Цалингийн урьдчилгаа	613,305.00	363,305.00
35	БАРАА МАТЕРИАЛ	94,377,784.00	93,005,682.00
351	Түүхий эд материал	19,617,513.00	28,552,113.00
35110	Тусгай зориулалттай материал	19,617,513.00	28,552,113.00
354	Хангамжийн материал	70,800,271.00	55,493,569.00
35410	Бичиг хэргийн материал	5,273,975.00	3,132,505.00
35420	Аж ахуйн материал	6,977,520.00	4,569,448.00
35430	Сэлбэг хэрэгсэл	14,813,860.00	5,635,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,441,000.00	408,900.00
35450	Барилгын засварын материал	5,672,850.00	5,299,350.00
35470	Бусад хангамжийн материал	36,621,066.00	36,447,866.00
35600	Мал амьтад	3,960,000.00	8,960,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	933,956,461.91	1,134,228,752.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	933,956,461.91	1,134,228,752.65
392	Биет хөрөнгө	911,664,461.91	1,111,936,752.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	587,729,784.00	636,146,243.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(210,588,277.34)	(246,012,537.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	94,800,000.00	186,477,440.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(54,799,047.39)	(82,265,867.75)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,038,176.62	41,460,376.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,238,547.59)	(13,646,289.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,877,074.00	44,364,950.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,761,191.30)	(23,131,453.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	818,284,713.00	1,034,663,225.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(363,823,222.09)	(466,915,834.60)
39217	Ном	145,000.00	796,500.00
393	Биет бус хөрөнгө	22,292,000.00	22,292,000.00
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.00)	(500,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,292,000.00	22,292,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,039,276,147.43	1,235,054,406.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	143,894.00	9,065,501.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	143,894.00	9,065,501.00
413	Өглөг	143,894.00	9,065,501.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,396,607.00
4136	Бусад өглөг	143,894.00	4,668,894.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,725,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	143,894.00	1,943,894.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,039,132,253.43	1,225,988,905.65
51	Засгийн газрын хувь оролцоо	1,039,132,253.43	1,225,988,905.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	165,881,058.00	165,881,058.00
51101	Өмч: - төрийн	165,881,058.00	165,881,058.00

512	Хуримтлагдсан үр дүн	701,367,010.75	888,223,662.97
51210	Өмнөх үеийн үр дүн	701,367,010.75	701,367,010.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	186,856,652.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171,884,184.68	171,884,184.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,039,276,147.43</u>	<u>1,235,054,406.65</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	667,379,867.00	1,030,537,820.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,224,072.00	1,030,537,820.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,224,072.00	374,377,711.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,224,072.00	422,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,264,072.00	422,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,960,000.00	373,955,111.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	638,155,795.00	656,160,109.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	696,095.00	24,535,709.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	696,095.00	21,675,709.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,860,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	637,459,700.00	631,624,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	637,459,700.00	631,624,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	875,248,855.36	843,681,167.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	875,248,855.36	843,681,167.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	805,990,627.98	814,380,632.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	360,323,620.00	431,080,017.52
210101	Үндсэн цалин	360,323,620.00	431,080,017.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,943,561.40	52,856,207.02
210201	Тэтгэврийн даатгал	30,488,901.57	36,633,294.12
210202	Тэтгэмжийн даатгал	3,578,759.74	4,303,102.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,792,749.15	2,151,551.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,614,074.75	1,953,652.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,469,076.19	7,814,607.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,249,136.50	48,002,030.04
210301	Гэрэл, цахилгаан	6,656,064.50	10,242,958.04
210302	Түлш, халаалт	36,339,072.00	37,059,072.00
210303	Цэвэр, бохир ус	1,254,000.00	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,203,595.00	37,882,780.00
210401	Бичиг хэрэг	6,149,600.00	5,746,270.00
210402	Тээвэр, шатахуун	17,740,605.00	18,836,587.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,533,000.00	8,189,653.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,431,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,780,390.00	3,678,670.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,731,000.00	15,353,560.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	3,594,000.00	-
210604	Урсгал засвар	1,137,000.00	15,353,560.00
2107	Томилолт, зочны зардал	12,228,000.00	7,575,700.00
210702	Дотоод албан томилолт	12,228,000.00	7,575,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,085,687.20	1,905,316.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,825,250.00	622,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	448,846.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	580,478.00	248,810.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	13,500.00	143,512.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	305,600.00	305,600.00
210807	Газрын төлбөр	360,859.20	136,048.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	292,226,027.88	219,725,022.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,977,000.00	41,564,202.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,229,600.00	2,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	271,019,427.88	176,160,820.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,258,227.38	29,300,534.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,897,000.00	10,212,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,502,000.00	8,712,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,395,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41,361,227.38	19,088,534.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,361,227.38	19,088,534.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(207,868,988.36)</u>	<u>186,856,652.22</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(207,868,988.36)</u>	<u>186,856,652.22</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	643,419,867.00	656,582,709.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,003,072.00	422,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,003,072.00	422,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,003,072.00	422,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,003,072.00	422,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	639,416,795.00	656,160,109.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,957,095.00	24,535,709.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	696,095.00	1,675,709.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,261,000.00	2,860,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	637,459,700.00	631,624,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	637,459,700.00	631,624,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	615,426,895.00	659,432,709.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,426,895.00	659,432,709.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,498,667.62	627,022,988.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,558,979.69	427,439,302.17
210101	Үндсэн цалин	228,997,240.69	259,187,295.17
210102	Нэмэгдэл	108,569,317.00	149,545,433.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,275,000.00	13,762,524.00
210104	Урамшуулал	11,717,422.00	4,944,050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,114,449.23	53,276,783.85
210201	Тэтгэврийн даатгал	31,386,729.84	36,337,399.58
210202	Тэтгэмжийн даатгал	3,466,907.98	4,275,318.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,913,469.07	2,137,499.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,372,912.99	2,137,498.60
210205	Эрүүл мэндийн даатгал	5,974,429.35	8,389,067.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,129,136.50	43,616,499.24
210301	Гэрэл, цахилгаан	6,656,064.50	9,935,034.24
210302	Түлш, халаалт	37,219,072.00	32,981,465.00
210303	Цэвэр, бохир ус	1,254,000.00	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,299,145.00	21,919,063.80
210401	Бичиг хэрэг	5,016,100.00	1,721,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,531,845.00	11,238,810.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,171,000.00	7,870,653.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,319,200.00	560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,261,000.00	528,600.00
2105	Нормативт зардал	2,539,970.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,539,970.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,666,500.00	16,124,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,383,000.00	10,540,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,283,500.00	584,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,228,000.00	7,395,000.00

210702	Дотоод албан томилолт	12,228,000.00	7,395,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,865,687.20	5,660,339.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,647,450.00	4,377,523.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	448,846.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	241,010.00	248,810.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	13,500.00	143,512.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,285,600.00	305,600.00
210807	Газрын төлбөр	678,127.20	136,048.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,096,800.00	50,092,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,192,200.00	48,092,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,904,600.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,928,227.38	32,409,720.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,497,000.00	10,212,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,502,000.00	8,712,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,995,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41,431,227.38	22,197,720.94
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,431,227.38	19,088,534.94
213404	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,109,186.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>27,992,972.00</u>	<u>(2,850,000.00)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,059,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,059,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	24,059,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,059,900.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(24,059,900.00)</u>	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,933,072.00	(2,850,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,933,072.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,933,072.00	1,083,072.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,881,058.00	171,884,184.68	909,305,999.11	1,247,071,241.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	165,881,058.00	171,884,184.68	909,305,999.11	1,247,071,241.79
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(207,938,988.36)	(207,938,988.36)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,881,058.00	171,884,184.68	701,367,010.75	1,039,132,253.43
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	165,881,058.00	171,884,184.68	701,367,010.75	1,039,132,253.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	165,881,058.00	171,884,184.68	701,367,010.75	1,039,132,253.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	186,856,652.22	186,856,652.22
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	165,881,058.00	171,884,184.68	888,223,662.98	1,225,988,905.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	631,624,400.00	612,958,465.06	18,665,934.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	631,624,400.00	612,958,465.06	18,665,934.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	621,329,400.00	602,746,465.06	18,582,934.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	427,498,300.00	427,439,302.17	58,997.83
210101	Үндсэн цалин	268,000,000.00	259,187,295.17	8,812,704.83
210102	Нэмэгдэл	121,498,300.00	149,545,433.00	(28,047,133.00)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,000,000.00	13,762,524.00	4,237,476.00
210104	Урамшуулал	20,000,000.00	4,944,050.00	15,055,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,437,400.00	53,276,783.85	160,616.15
210201	Тэтгэврийн даатгал	36,337,400.00	36,337,399.58	0.42
210202	Тэтгэмжийн даатгал	4,275,000.00	4,275,318.99	(318.99)
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,137,500.00	2,137,499.41	0.59
210204	Ажилгүйдлийн даатгал	2,137,500.00	2,137,498.60	1.40
210205	Эрүүл мэндийн даатгал	8,550,000.00	8,389,067.27	160,932.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,616,500.00	43,616,499.24	0.76
210301	Гэрэл, цахилгаан	12,477,500.00	9,935,034.24	2,542,465.76
210302	Түлш, халаалт	29,339,000.00	32,981,465.00	(3,642,465.00)
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	700,000.00	1,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,400,100.00	21,919,063.80	4,481,036.20
210401	Бичиг хэрэг	2,500,100.00	1,721,000.00	779,100.00
210402	Тээвэр, шатахуун	13,000,000.00	11,238,810.80	1,761,189.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,000,000.00	7,870,653.00	129,347.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	560,000.00	390,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,950,000.00	528,600.00	1,421,400.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,125,000.00	16,124,000.00	1,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,585,000.00	10,540,000.00	45,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	540,000.00	584,000.00	(44,000.00)
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	7,395,000.00	1,605,000.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	7,395,000.00	1,605,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,052,100.00	4,233,816.00	6,818,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,782,900.00	2,951,000.00	5,831,900.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,200.00	-	324,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	448,846.00	101,154.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	248,810.00	1,190.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	145,000.00	143,512.00	1,488.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	305,600.00	144,400.00
210807	Газрын төлбөр	550,000.00	136,048.00	413,952.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,700,000.00	27,242,000.00	5,458,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,750,000.00	25,242,000.00	4,508,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,950,000.00	2,000,000.00	950,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,295,000.00	10,212,000.00	83,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,295,000.00	10,212,000.00	83,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,712,000.00	8,712,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,583,000.00	1,500,000.00	83,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	631,624,400.00	612,958,465.06	19,265,934.94
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	631,624,400.00	612,535,865.06	19,088,534.94
132001	Орон нутгийн төсвөөс	631,624,400.00	612,535,865.06	19,088,534.94
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		422,600.00	(422,600.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		422,600.00	(422,600.00)
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,535,709.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,535,709.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,426,523.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,426,523.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,426,523.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,109,186.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,109,186.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,535,709.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,535,709.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,675,709.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,860,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар 225,594.3 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

Залруулсан алдаа:

1. ЗДТГ-аас болон Орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй хүлээн авсан 196,763.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүйгээс, ном дансны дэлгэрэнгүй тайланд бүртгэлтэй 651.5 мянган төгрөгийн хөрөнгө байдлын тайланд бүрэн татагдаагүйгээс үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл санхүүгийн тайланд зөрүүтэй тусгагдсан байна.
2. Үнэ төлбөргүйгээр хүлээн авсан үндсэн хөрөнгийг орлогод авч санхүүгийн тайланд тусгаагүйгээс авто тээврийн хэрэгсэл дансны элэгдлийн зардал 6,422.2 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө дансны элэгдлийн зардал 21,757.4 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд дутуу илэрхийлэгдсэн алдааг тус тус залрууллаа.

Аудитаар илэрсэн 20,883.9 мянган төгрөгийн зөрчилд 791.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 20,092.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд 2 ажилтанд ээлжийн амралтын хугацаанд 791,295.10 (долоон зуун ерэн нэгэн мянга хоёр зуун ерэн таван төгрөг арван мөнгө) төгрөгийн цалинг давхардуулан тооцон олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

1. Үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас олон нийтийн цагдаагийн цалинд 11,583,600.00 (арван нэгэн сая таван зуун наян гурван мянга зургаан зуу) төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас цагдаагийн хувцас хэрэглэлд 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас цол ахиулан амжилт гаргасан бөхөд мялаалга 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас малчдын сургалт, сурталчилгаанд 2,000,000.00 (Хоёр сая) төгрөг, нийт 16,583,600.00 (арван зургаан сая таван зуун наян гурван мянга зургаан зуу) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд байгууллагын хэрэгцээнд 2 төрлийн интернэт сүлжээг зэрэгцүүлэн ашиглаж 3,509,000.00 (гурван сая таван зуун есөн мянга) төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Байхгүй

Аудитаар нийт 20,883.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс өндөр тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаг даагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн үлдэгдэлийг зөрүүтэй тусгасан	1	197,414.7	1	197,414.7			1	197,414.7				
Элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн	1	28,179.6	1	28,179.6			1	28,179.6				
Дүн	2	225,594.3	2	225,594.3			2	225,594.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	16,583.6			1	16,583.6						
Төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	3,509.0			1	3,509.0						
Илүү цалин олгосон	1	791.3	1	791.3								
Дүн	3	20,883.9	1.0	791.3	2.0	20,092.6	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаар-лалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 52-А/2371281

Чингис хот

ХЭА-2026/111/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 2 ажилтанд ээлжийн амралтын хугацаанд 791,295.10 (долоон зуун ерэн нэгэн мянга хоёр зуун ерэн таван төгрөг арван мөнгө) төгрөгийн цалинг давхардуулан тооцон олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү тооцож олгосон 791,295.10 (долоон зуун ерэн нэгэн мянга хоёр зуун ерэн таван төгрөг арван мөнгө) төгрөгийг нягтлан бодогч Б.Анхтуяагаар төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга М.Мөнхжаргалд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ФАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 99-А 2371281

Чингис хот

ХЭА-2026/111/НА-СТА-ТШЗ

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Гурванбаян тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын хэрэгцээнд 2 төрлийн интернэт сүлжээг зэрэгцүүлэн ашиглаж 3,509,000.00 (гурван сая таван зуун есөн мянга) төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга М.Мөнхжаргал, нягтлан бодогч Б.Анхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Н. Хэрлэнбаяр



Ж.ГАНБААТАР
Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 125-А2371281

Чингис хот

ХЭА-2026/111/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас олон нийтийн цагдаагийн урамшуулалд 11,583,600.00 (арван нэгэн сая таван зуун наян гурван мянга зургаан зуу) төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас цагдаагийн хувцас хэрэглэлд 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас цол ахиулан амжилт гаргасан бөхөд мялаалга 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас малчдын сургалт, сурталчилгаанд 2,000,000.00 (Хоёр сая) төгрөг, нийт 16,583,600.00 (арван зургаан сая таван зуун наян гурван мянга зургаан зуу) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга М.Мөнхжаргал, нягтлан бодогч Б.Анхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Н.ХЭРЛЭНБАЯР